

Өвөрхангай аймгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны хөгжлийн 2004 оны гүйцэтгэлийн талаархи танилцуулга

Нэг: Нийгэм

Хүн ам

2004 оны эцсээр Өвөрхангай аймгийн суурин хүн ам 108429 болж, үүнээс эрэгтэй 53501, эмэгтэй 54988 хүн байна. Энэ онд 2170 хүүхэд төрж, 635 хүн нас барж, УБ болон бусад аймаг хотруу 3069 хүн шилжиж, 236 хүн шилжиж ирсэн байна. Нийт хүн амын 58.4 хувь нь нь хөдөлмөрийн насны хүн ам, 35.4 хувь нь 15 хүртэлх насны хүүхэд, 10.5 хувь нь 60-аас дээш насны хүн ам эзэлж байна. Хөдөлмөрийн насны хүн амын 72.0 хувь буюу 45.5 мян. хүн ажил хөдөлмөр эрхэлж байна. Хөдөлмөр эрхлээгүй 9.5 мян. хүн байгаагийн 2.3 мян. хүн нь хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн байна.

Аймаг 28429 өрхтэй. Үүний 40.6 хувь нь сумын төвд, 59.1 хувь нь хөдөөд оршин сууж байна.

Боловсрол

Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын бага, дунд 28 сургуульд 830 багш ажиллаж, 687 бүлэгт 23384 сурагч суралцаж байна. Аймгийн дүнгээр авч үзвэл: 1 бүлэгт 34 сурагч ноогдож байгаа боловч Уянга, Арвайхээр сумын 1.2-р 10 жилийн сургуульд 38 хүүхэд ноогдож байгаа нь аймгийн дундаас 4-н сурагчаар их байна. Сургуулийн дотуур байрнуудад 2932 хүүхэд амьдарч байна. Сургуулийн өмнөх насны 28 байгууллагад 3103 хүүхэд хүмүүжиж байна.

Эрүүл мэнд

2004 онд 2168 эх амаржиж, 0-1 хүртлэх насандаа 31 хүүхэд эндсэн нь урьд оны мөн үеэс 54.4 хувиар буурчээ. Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 1059 болж урьд оны мөн үеэс 63-аар нэмэгдсэн байна. Төрөхийн улмаас 2 эх эндсэн байна.

Гэмт хэрэг

2004 онд 556 гэмт хэрэг үйлдэгдсэн нь өмнөх оныхоос 37 хэргээр нэмэгдсэн байна. Бусдыг санаатай алсан хэрэг 13 гарч өмнөх оныхоос 2-оор өссөн. Нийт гэмт хэргийн дотор иргэдийн өмчийн хулгай 50.5 хувийг эзэлж байна. Хэрэг үйлдэгчдийн тоо 568 байгаагийн 385 нь буюу 67.8 хувь нь 18-35 насны залуучууд байна. Гэмт хэргийн улмаас иргэдэд 246.7 сая, төгрөгийн хохирол учирсан байна.

Хоёр: Эдийн засаг

2004 онд аймгийн татварын албанд албан ёсоор бүртгэлтэй 376 аж ахуйн нэгж байна. Үүнд: ОНӨААҮГ-3, ТӨҮГ-4, ХК-18, ХХК-182, нөхөрлөл-71, хоршоо-98 байна.

Төсөв санхүү

2004 онд аймгийн төсвийн нийт орлого 1392.0 сая. төгрөг орж төлөвлөгөөний биелэлт 109.9 хувьтай байна. Үүний 3.5 хувийг өөрийн орлого эзэлж байна. Нийт орлогын 37.8 хувь буюу 526.1 сая. төгрөг нь нэмэгдсэн өртгийн болон онцгой албан татварын шилжүүлгийн орлого байна. Сумдын төсвийн орлогод 1314.6 сая төгрөг орсон байна.

Улсаас орон нутгийн санхүүжилтэнд 542.0 сая төгрөг, төвлөрсөн төсвийн байгууллагын санхүүжилтэнд 5590.3 сая төгрөгийн татаац авсан байна.

Төсвийн нийт зарлага 8495.1 сая төгрөг болсны 37.4 хувийг цалин хөлс, 7.6 нийгмийн даатгалын шимтгэл, 1.7 хувийг эрүүл мэндийн даатгал, 45.1 хувийг бараа үйлчилгээ, 6.8 хувийг хөрөнгө оруулалт, их засварын зардал, тус тус санхүүжүүлсэн байна. Төсөвт газрууд 3.9 сая. төгрөгийн авлагатай, 63.1 сая өглөгтэй гарсан байна.

Аймгийн нийгмийн даатгалын сангуудын орлого 5584.1 сая. төг болж төлөвлөгөө 104.2 хувиар биелэгдсэн байна. Бүх төрлийн тэтгэвэрт 4642.1 сая төгрөг, тэтгэмжид 110.3 сая төгрөг олгож, жилд олговол зохих тэтгэвэр тэтгэмжийг 100.0 хувь олгожээ. Нийгмийн халамжийн үйлчилгээнд 1300.3 сая төгрөг зарцуулсан байна.

Арилжааны банкуудын мэдээгээр ХААН, Монгол шуудан, Зоос, Хас банкнаас аж ахуй нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 5619.9 сая төгрөгт хүрсэн нь 2003

оны жилийн эцсийнхээс 1742.4 саяар өсч, хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 73.1 сая төгрөг байна.

Дээрхи банкуудад иргэд, байгууллагуудын хадгалуулсан хадгаламжийн хэмжээ 3086.0 сая төгрөг болж урьд оныхоос 60.7 дахин нэмэгдсэн байна.

Банкуудын хугацаатай хадгаламжийн хүүний дундаж 1.0-1.6 хувь, хугацаагүй хадгаламжийн хүүний дундаж 0.5-0.8 хувь, зээлийн хүү 3.0-5.0 хувь байна.

Хөдөө аж ахуй

2004 онд 709.4 мянган төл бойжиж, 8.4 мян.мал хорогдож аймгийн мал 2155452 толгой болж өмнөх оноос дүнгээрээ 236620 толгойгоор өссөн байна. Үүнээс тэмээ 13832, адуу 132943, үхэр 91218, хонь 971500, ямаа 945959 толгой болсон дүн мэдээ гарлаа. Нийт малын 38.7 хувь нь хээлтэгч мал эзэлж байна. Сумдыг малынх нь тоогоор авч үзвэл: Баянгол сум 221477 толгой, Богд 190746 толгой, Сант 168750 толгой, Баянөндөр 137608 толгой, Уянга сум 126116 толгой малаар эхний 5 байранд байна. Аймгийн хэмжээгээр мянга түүнээс дээш малтай өрх 30 байна.

Малтай өрх 19976 байгаагийн 1519 нь 10 хүртэл толгой малтай, 3009 өрх 11-30 толгой малтай, 2890 өрх 31-50 толгой малтай, 5118 өрх 51-100 толгой малтай, 4399 өрх 101-200 толгой малтай, 2797 өрх 201-500 толгой малтай, 214 өрх 501-999 толгой малтай, 28 өрх 1000-аас дээш малтай байна. Малтай өрхөөс 1374 өрх авто машинтай, 3984 өрх мотоцикльтай, 65 өрх трактортой, 5521 өрх цахилгаан үүсгэвэртэй, 4358 өрх телевизортой байна. Малчид энэ онд 26.8 мян.метр эсгий хийжээ.

Аймгийн хэмжээнд 3639 га-д үр тариа, 211.3 га-д төмс, 93.3 га-д хүнсний ногоо тариалж, үр тариа 1331.9 тн, төмс 1803.9 тн, хүнсний ногоо 883.5 тн-ыг хураан авсан байна. Малчид 20.3 мян. тн байгалийн хадлан, 4.2 мянган тн гар тэжээл бэлтгэжээ.

Үйлдвэрлэл үйлчилгээ

Аж үйлдвэрийн чиглэлийн аж ахуйн нэгж, цэг салбарууд 1567.4 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 1615.9 сая.төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна.

Нийт үйлдвэрлэлтэд хүнснийх 48.8 хувь, цахилгаан дулааных 24.2 хувь, нүүрснийх 21.3 хувь, мод модон эдлэл 4.0 хувь, хэвлэлийнх 0.4 хувь, бусад үйлдвэрлэл 1.3 хувийг тус тус эзэлж байна.

Барилгын аж ахуйн нэгжүүд 479.2 сая төгрөгийн барилга угсралт их засварын ажил хийлээ.

Тээвэр бүхий байгууллага, иргэд нийт 437.1 сая төгрөгний орлоготой ажиллаж өмнөх оны мөн үеээс 71.9 хувиар өссөн байна. 9.3 мян.тн ачаа, давхардсан тоогоор 102.0 мянган зорчигч тээвэрлэлээ.

Холбооны тарифын орлого урьд оны мөн үеэс 44.0 сая төгрөгөөр өсч 592.1 сая төгрөг болсны дотор хүн амаас орсон орлого 17.6 саяар өсч 346.4 сая төгрөгт хүрсэн байна. Өмнөх оны мөн үеэс телефон цэгийн тоо 215-аар нэмэгдэж 3210 болсон байна.

Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж, цэг салбарууд 2738.5 сая.төгрөгийн бараа борлуулалт хийжээ. Аймгийн төвийн зочид буудлууд 60.5 сая төгрөгийн орлого үйлчилгээ хийсэн байна.

Гурав: Байгаль орчин

Аймаг нийтдээ 6289533.0 га нутаг дэвсгэртэй. Үүний 5767846.9 га нь Хөдөө аж ахуйн газар байдаг. Үүнээс 5717001.9 га-д бэлчээрийн, 5821.8 га-д хадлангийн, 6949.5 га-д тариалангийн, 36981.7 га нь атаршсан талбай эзэлдэг.

Нийт талбайн 192278.0 га-д ойн сан, 3318.3 га-д усан сан бүхий талбайнууд байдаг. Нийт 104419 га талбай бүхий үзэсгэлэнт 10 газар тусгай хамгаалалтанд байдаг.

Засаг даргын дэргэдэх статистикийн хэлтэс